

# ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДАА-2026/30/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дархан-Уул аймаг 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Н.Хулансүрэн Утас: 70373089 Цахим хаяг: Khulansuren@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр бөг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059  
Утас: 7037-3089 Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.24 № 54

талай \_\_\_\_\_ -ныг № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд журамд заасан хувь хэмжээг мөрдөөгүйгээс 714.1 мянган төгрөгийн төрийн албан хаасан хугацааны нэмэгдэл цалин, 2 сарын хугацаанд түр орлон гүйцэтгэсэн албан хаагчид үндсэн цалингийн 40 хувиар тооцож 602.0 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс, журамд заагаагүй албан тушаалтнуудад 32,573.6 мянган төгрөгийн хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгож, залруулагдаагүй нийт 33,889.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон 12,368.4 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын 2.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын "Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа төрийн үйлчилгээний зарим албан хаагчид хөдөлмөрийн нөхцлийн нэмэгдэл олгох журам"-ын 2, 3, "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 5 дахь хэсэгтэй нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус байгууллагын санаачилгаар НҮБ-ын хүүхдийн сангаас бага насны хүүхдийн хөгжил, хүүхдүүдийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор усан эмчилгээний өрөөний тохижилт засварт

4527050198

13,850.0 мянган төгрөг, тэдний эцэг эх, асран хамгаалагчид стандартад нийцсэн суралцах орчин бүрдүүлэхэд 27,800.0 мянган төгрөг, нийт 41,650.0 мянган төгрөгийн сургалтын төхөөрөмж, сандал, хэрэглэгдэхүүн зэргийг үндсэн хөрөнгөд бүртгэж, толилуулсан байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2025 оны "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн бүтэц, орон тоо, дүрмийг шинэчлэн батлах тухай" А/133 дугаар тушаалын дагуу "Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв" УТҮГ-аас Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын харьяанд шилжснээр 1,196,133.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулсан байна.

#### **Бусад асуудал**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 47 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 86.0 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>124,011,875.40</b>	<b>124,792,574.50</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>6</b>	<b>124,011,875.40</b>	<b>124,792,574.50</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>		<b>884,265.00</b>	<b>1,009,265.00</b>
35110	Тусгай зориулалттай материал		884,265.00	884,265.00
35130	Эм боох материал		-	125,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>		<b>123,127,610.40</b>	<b>123,783,309.50</b>
35420	Аж ахуйн материал		4,007,000.00	1,547,000.00
35440	Түлш, шатах тослох материал		1,275,742.90	190,250.00
35450	Барилгын засварын материал		-	3,500.00
35470	Бусад хангамжийн материал		117,844,867.50	122,042,559.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>1,338,954,500.37</b>	<b>1,217,927,394.70</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>7</b>	<b>1,338,954,500.37</b>	<b>1,217,927,394.70</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>		<b>1,157,331,083.77</b>	<b>1,037,231,644.82</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл		82,482,420.00	82,482,420.00
39204	Хуримтлагдсан элэгдэл/Авто-тээврийн хэрэгсэл		(859,191.88)	(11,169,494.44)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		1,036,978,360.90	1,066,054,525.90
39206	Хуримтлагдсан элэгдэл		(142,002,784.77)	(279,823,022.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		188,133,708.58	210,901,188.58
39208	Хуримтлагдсан элэгдэл		(21,901,779.06)	(44,201,242.33)
39214	Бусад үндсэн хөрөнгө		15,130,800.00	15,130,800.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(630,450.00)	(2,143,530.00)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>		<b>181,623,416.60</b>	<b>180,695,749.88</b>
39301	Програм хангамж		2,783,000.00	2,783,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(1,159,583.40)	(2,087,250.12)
39303	Бусад биет бус хөрөнгө		180,000,000.00	180,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>1,462,966,375.77</b>	<b>1,342,719,969.20</b>
<b>4</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		-	<b>1,355,500.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		-	<b>1,355,500.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>9</b>	-	<b>1,355,500.00</b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>		-	<b>1,355,500.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг		-	858,950.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		-	496,550.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧ</b>		<b>1,462,966,375.77</b>	<b>1,341,364,469.20</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		<b>1,462,966,375.77</b>	<b>1,341,364,469.20</b>
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		<b>1,462,966,375.77</b>	<b>1,341,364,469.20</b>
51210	Өмнөх үеийн үр дүн		-	1,462,966,375.77
51220	Тайлант үеийн үр дүн		1,462,966,375.77	(121,601,906.57)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>		<b>1,462,966,375.77</b>	<b>1,342,719,969.20</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2</b>	<b>2,451,292,624.46</b>	<b>1,278,339,560.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>1,484,059,924.46</b>	<b>19,191,960.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		<b>1,484,059,924.46</b>	<b>19,191,960.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		-	485,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		-	485,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		1,363,669,534.46	13,394,150.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		120,390,390.00	5,312,810.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>967,232,700.00</b>	<b>1,259,147,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>		<b>964,265,700.00</b>	<b>1,196,133,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		964,265,700.00	1,196,133,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>2,967,000.00</b>	<b>63,014,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,967,000.00	800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		-	60,065,000.00
131105	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		-	2,149,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>3</b>	<b>988,326,248.69</b>	<b>1,399,941,466.57</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>988,326,248.69</b>	<b>1,399,941,466.57</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>841,734,027.93</b>	<b>1,228,583,678.01</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>582,591,289.06</b>	<b>823,777,731.00</b>
210101	Үндсэн цалин		344,327,121.09	441,623,827.60
210102	Нэмэгдэл		124,921,167.97	243,051,597.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт		62,014,000.00	80,668,636.36
210104	Урамшуулал		51,329,000.00	58,433,670.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>74,509,819.02</b>	<b>98,065,318.02</b>
210201	Тэтгэврийн даатгал		51,803,186.71	67,393,008.03
210202	Тэтгэмжийн даатгал		5,883,040.48	8,369,988.77
210203	ҮОМШӨ-ний даатгал		3,146,000.00	4,732,752.27
210204	Ажилгүйдлийн даатгал		2,922,688.04	3,513,913.76
210205	Эрүүл мэндийн даатгал		10,754,903.79	14,055,655.19
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		<b>27,881,788.92</b>	<b>27,751,752.08</b>
210301	Гэрэл, цахилгаан		8,327,255.76	10,538,223.89
210302	Түлш, халаалт		17,043,884.96	13,947,911.20
210303	Цэвэр, бохир ус		2,510,648.20	3,265,616.99
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>23,201,967.60</b>	<b>32,170,739.90</b>
210401	Бичиг хэрэг		5,947,400.00	10,869,305.00
210402	Тээвэр, шатахуун		3,040,657.10	3,485,492.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		3,766,298.00	3,595,714.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		2,286,240.00	405,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		8,161,372.50	12,537,028.00

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	1,278,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>20,335,068.00</b>	<b>11,702,730.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,759,368.00	10,902,730.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,575,700.00	800,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,719,620.00</b>	<b>5,393,700.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,089,100.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	893,250.00	-
210604	Урсгал засвар	9,737,270.00	5,393,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>43,249,291.24</b>	<b>34,701,956.34</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,963,200.00	33,295,283.50
210803	Даатгалын үйлчилгээ	75,141.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33,500.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,400.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	930,050.24	1,369,672.84
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,215,000.00	37,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>57,245,184.09</b>	<b>195,019,750.67</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	15,989,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,528,800.00	6,160,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	50,716,384.09	172,870,750.67
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>146,592,220.76</b>	<b>171,357,788.56</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,720,000.00</b>	<b>-</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,720,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>142,872,220.76</b>	<b>171,357,788.56</b>
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	-	9,409,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	142,872,220.76	161,948,788.56
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III = I - II)</b>	<b>1,462,966,375.77</b>	<b>(121,601,906.57)</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>6</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI = IV - V)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>7</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (VII = III + VI)</b>	<b>1,462,966,375.77</b>	<b>(121,601,906.57)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>967,232,700.00</b>	<b>1,259,632,600.00</b>
<b>I.I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>967,232,700.00</b>	<b>1,259,632,600.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>485,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	<b>485,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	485,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	485,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>967,232,700.00</b>	<b>1,259,147,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>964,265,700.00</b>	<b>1,196,133,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	964,265,700.00	1,196,133,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,967,000.00</b>	<b>63,014,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,967,000.00	800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	60,065,000.00
131105	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,149,000.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>941,231,350.00</b>	<b>1,221,183,105.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>941,231,350.00</b>	<b>1,221,183,105.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>794,639,129.24</b>	<b>1,049,825,316.44</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>582,591,289.06</b>	<b>823,777,731.00</b>
210101	Үндсэн цалин	344,327,121.09	433,431,156.43
210102	Нэмэгдэл	124,921,167.97	251,244,268.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	62,014,000.00	80,939,576.36
210104	Урамшуулал	51,329,000.00	58,162,730.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>74,509,819.02</b>	<b>98,065,318.02</b>
210201	Тэтгэврийн даатгал	51,803,186.71	67,393,008.03
210202	Тэтгэмжийн даатгал	5,883,040.48	8,369,988.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,146,000.00	4,732,752.27
210204	Ажилгүйдлийн даатгал	2,922,688.04	3,513,913.76
210205	Эрүүл мэндийн даатгал	10,754,903.79	14,055,655.19
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>27,881,788.92</b>	<b>27,751,752.08</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,327,255.76	10,538,223.89
210302	Түлш, халаалт	17,043,884.96	13,947,911.20
210303	Цэвэр, бохир ус	2,510,648.20	3,265,616.99
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,185,188.00</b>	<b>15,294,324.00</b>
210401	Бичиг хэрэг	2,937,400.00	2,971,800.00
210402	Тээвэр, шатахуун	4,316,400.00	2,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,766,298.00	3,595,714.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,286,240.00	405,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,878,850.00	5,921,810.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>20,335,068.00</b>	<b>10,413,980.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,759,368.00	9,313,980.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,575,700.00	1,100,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,553,385.00</b>	<b>3,815,750.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,089,100.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,372,265.00	38,500.00
210604	Урсгал засвар	11,092,020.00	3,777,250.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>47,935,291.24</b>	<b>35,126,456.34</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,463,200.00	33,295,283.50

210803	Даатгалын үйлчилгээ	75,141.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33,500.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,400.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	930,050.24	1,369,672.84
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,401,000.00	461,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,647,300.00</b>	<b>35,580,005.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал/Бараа үйлчилгээний бусад зардал	-	29,290,005.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,647,300.00	6,290,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>146,592,220.76</b>	<b>171,357,788.56</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,720,000.00</b>	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,720,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>142,872,220.76</b>	<b>171,357,788.56</b>
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	-	9,409,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	142,872,220.76	161,948,788.56
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ( III = I - II)</b>	<b>26,001,350.00</b>	<b>38,449,495.00</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	-	-
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>26,001,350.00</b>	<b>38,449,495.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>26,001,350.00</b>	<b>38,449,495.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	26,001,350.00	38,449,495.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(26,001,350.00)</b>	<b>(38,449,495.00)</b>
<b>VII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>VIII</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>IX</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	-	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	1,462,966,375.77	-	1,462,966,375.77
C08	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>1,462,966,375.77</b>	-	<b>1,462,966,375.77</b>
D01	<b>2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>1,462,966,375.77</b>	-	<b>1,462,966,375.77</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	<b>1,462,966,375.77</b>	-	<b>1,462,966,375.77</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(121,601,906.57)	-	(121,601,906.57)
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>1,341,364,469.20</b>	-	<b>1,341,364,469.20</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,236,839,000.00</b>	<b>1,034,669,811.44</b>	<b>(202,169,188.56)</b>	<b>83.7</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,236,839,000.00</b>	<b>1,034,669,811.44</b>	<b>(202,169,188.56)</b>	<b>83.7</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,236,839,000.00	1,034,669,811.44	(202,169,188.56)	83.7
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,236,839,000.00</b>	<b>1,034,669,811.44</b>	<b>(202,169,188.56)</b>	<b>83.7</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,236,839,000.00</b>	<b>1,034,669,811.44</b>	<b>(202,169,188.56)</b>	<b>83.7</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,236,839,000.00</b>	<b>1,034,669,811.44</b>	<b>(202,169,188.56)</b>	<b>83.7</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>948,437,800.00</b>	<b>823,777,731.00</b>	<b>(124,660,069.00)</b>	<b>86.9</b>
210101	Үндсэн цалин	449,277,300.00	433,431,156.43	(15,846,143.57)	96.5
210102	Нэмэгдэл	324,867,100.00	251,244,268.21	(73,622,831.79)	77.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	99,591,100.00	80,939,576.36	(18,651,523.64)	81.3
210104	Урамшуулал	74,702,300.00	58,162,730.00	(16,539,570.00)	77.9
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>118,344,200.00</b>	<b>98,065,318.02</b>	<b>(20,278,881.98)</b>	<b>82.9</b>
210201	Тэтгэврийн даатгал	80,492,100.00	67,393,008.03	(13,099,091.97)	83.7
210202	Тэтгэмжийн даатгал	9,491,000.00	8,369,988.77	(1,121,011.23)	88.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,765,800.00	4,732,752.27	(33,047.73)	99.3
210204	Ажилгүйдлийн даатгал	4,719,000.00	3,513,913.76	(1,205,086.24)	74.5
210205	Эрүүл мэндийн даатгал	18,876,300.00	14,055,655.19	(4,820,644.81)	74.5
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>34,370,200.00</b>	<b>27,751,752.08</b>	<b>(6,618,447.92)</b>	<b>80.7</b>
210301	Гэрэл, цахилгаан	13,175,600.00	10,538,223.89	(2,637,376.11)	80.0
210302	Түлш, халаалт	17,006,700.00	13,947,911.20	(3,058,788.80)	82.0
210303	Цэвэр, бохир ус	4,187,900.00	3,265,616.99	(922,283.01)	78.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,898,700.00</b>	<b>14,294,324.00</b>	<b>(9,604,376.00)</b>	<b>59.8</b>
210401	Бичиг хэрэг	3,609,100.00	2,971,800.00	(637,300.00)	82.3
210402	Тээвэр, шатахуун	2,278,800.00	1,400,000.00	(878,800.00)	61.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,125,500.00	3,595,714.00	(3,529,786.00)	50.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,349,400.00	405,000.00	(1,944,400.00)	17.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,535,900.00	5,921,810.00	(2,614,090.00)	69.4
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>32,193,900.00</b>	<b>17,213,980.00</b>	<b>(14,979,920.00)</b>	<b>53.5</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	28,981,100.00	16,113,980.00	(12,867,120.00)	55.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,212,800.00	1,100,000.00	(2,112,800.00)	34.2
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>15,442,700.00</b>	<b>12,950,250.00</b>	<b>(2,492,450.00)</b>	<b>83.9</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,134,500.00	9,134,500.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,530,900.00	38,500.00	(2,492,400.00)	1.5
210604	Урсгал засвар	3,777,300.00	3,777,250.00	(50.00)	100.0

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>55,661,500.00</b>	<b>35,126,456.34</b>	<b>(20,535,043.66)</b>	<b>63.1</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,200,000.00	33,295,283.50	(9,904,716.50)	77.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,262,300.00		(2,262,300.00)	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	447,900.00		(447,900.00)	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	85,600.00		(85,600.00)	0.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	29,600.00		(29,600.00)	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,586,700.00	1,369,672.84	(2,217,027.16)	38.2
210807	Газрын төлбөр	100.00		(100.00)	0.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6,049,300.00	461,500.00	(5,587,800.00)	7.6
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,490,000.00</b>	<b>5,490,000.00</b>	<b>(3,000,000.00)</b>	<b>64.7</b>
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	8,490,000.00	5,490,000.00	(3,000,000.00)	64.7
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>27.00</b>	<b>26.00</b>	<b>(1.00)</b>	<b>96.3</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	19.00	(1.00)	95.0
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>ОРЛОГЫН ДҮН</b>	<b>53,605,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>53,605,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52,805,000.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>53,605,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>53,605,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>53,605,000.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,000,000.00</b>
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>52,605,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,805,000.00
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	800,000.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 54,151.7 мянган төгрөгийн 2 алдааг<sup>1</sup> аудитын явцад залруулав. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны хэсэгт 7,697.6 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлыг, 18,303.8 мянган төгрөгийн багаж, техник хэрэгслийн зардлыг илүү тусгаж илэрхийлснээс биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг 26,001.4 мянган төгрөгөөр дутуу тусгасан,
2. Санхүү үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланд туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих дүнг төсөвт байгууллагын өөрийн орлого дансанд бүртгэсэн нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх НББ-ийн журам”-ын 5.3, 5.7 дахь хэсэг, санхүүгийн тайлангийн “Толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй тул санхүүгийн тайлангийн холбогдох дансанд нэмж тусгаж, залруулав.

Мөн аудитаар илэрсэн 35,889.7 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup>-д 1,316.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 34,573.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэв.

#### 3.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг буруу тооцож олгосноос 2 албан хаагчид 714.1 мянган төгрөг, төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг 2 сарын хугацаанд түр орлон гүйцэтгэсэн албан хаагчид үндсэн цалингийн 40 хувиар нэмэгдэл цалин тооцсоноос 602.0 мянган төгрөг тус тус илүү олгож төсвийг үр ашиггүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5, 16.5.2, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.1, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын 5 дахь хэсэг, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоосон.

#### 3.2 Албан шаардлага

1. Хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журмыг мөрдөөгүйгээс байгууллагын дарга, албадын дарга нар болон нягтлан бодогч, нярав, хүний нөөц, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн, мэдээлэл харилцаа холбооны мэргэжилтэн, сантехникч, жолооч, үйлчлэгч зэрэг нийт 23 албан хаагчид 32,573.6 мянган төгрөгийн нэмэгдэл олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5, 16.5.5, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа төрийн үйлчилгээний зарим албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журам”-ын 2, 3 дахь хэсэг, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зардалд 2,000.0 мянган төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.4 дэх хэсэг, санхүүгийн тайлангийн *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны хэсэгт 7,697,550.00 төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлыг, 18,303,800.00 төгрөгийн багаж, техник хэрэгслийн зардлыг илүү тусгаж илэрхийлснээс биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг 26,001,350 төгрөгөөр дутуу тусгасан байна.	1	52,002.7	-	-	1	52,002.7	1	52,002.7	-	-	-	-
Санхүү үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланд туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих дүнг төсөвт байгууллагын өөрийн орлого дансанд бүртгэсэн байна.	1	2,149.0	-	-	1	2,149.0	1	2,149.0	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>54,151.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>54,151.7</b>	<b>2</b>	<b>54,151.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг буруу тооцож олгосноос 2 албан хаагчид 714,077.00 төгрөг, төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг 2 сарын хугацаанд түр орлон гүйцэтгэсэн албан хаагчид үндсэн цалингийн 40 хувиар нэмэгдэл цалин тооцоноос 602,000.00 төгрөг тус тус илүү олгож төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	1,316.1	1	1,316.1	-	-	-	-	-	-	-	-
Тус байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлээгүй дарга, албадын дарга нар, нягтлан бодогч, нярав, хүний нөөц, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн, мэдээлэл харилцаа холбооны мэргэжилтэн, сантехникч, жолооч, үйлчлэгч зэрэг нийт 23 албан хаагчдад 32,573,641.00 төгрөгийн хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	32,573.6	-	-	1	32,573.6	-	-	-	-	-	-
Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг олон	1	2,000.0	-	-	1	2,000.0	-	-	-	-	-	-

нийтэд сурталчлах зардалд 2,000,000.00 төгрөг зарцуулсан байна.												
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>35,889.7</b>	<b>1</b>	<b>1,316.1</b>	<b>2</b>	<b>34,573.6</b>	-	-	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тус байгууллага нь шилэн дансны цахим системд нийт 3,215,143,800.00 төгрөгийн 172 мэдээллийг хоцроож, 34,763,790.00 төгрөгийн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 4 шийдвэрийг байршуулаагүй байна.	1	3,249,907.6	-	-	-	-	1	3,249,907.6
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>3,249,907.6</b>	-	-	-	-	<b>1</b>	<b>3,249,907.6</b>